

Historic, harmonic and hospitable

# ULANBAATAR

— MONGOLIA



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР





## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

“Нийслэлийн Аялал жуулчлалын газар” нь нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх аялал жуулчлалын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, нийслэл хотыг гадаад дотоодод сурталчлах чиг үүрэг бүхий нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.

### Газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд

- Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, шинээр бий болгох
- Жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
- Улаанбаатар хотын гадаад сурталчилгааг явуулж, зорих газрын менежментийн бодлого, маркетингийн стратегийг хэрэгжүүлэх
- Жуулчдыг татах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын эдийн засаг, нийгмийн нөлөөллийг зохистой хэмжээнд байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах
- Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх
- Жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан төрөл бүрийн сургалт, судалгааны ажлууд зохион байгуулах
- Нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх

### 2014 онд хэрэгжүүлэх онцлох ажлууд

- “Найрсаг Улаанбаатар” аялал жуулчлал, соёл урлагийн хөтөлбөр боловсруулж, нийслэлийн иргэдийн гадаадын иргэд, жуулчдад чиглэсэн харилцаа, хандлагыг эерэг болгох нийгмийн аяныг зохион байгуулна.
- Гандангийн дэнжийг гар урлалын төв, шашны аялал жуулчлалын дагалдах үйлчилгээ, эртний эдлэлийн дэлгүүр, бэлэг дурсгалын төв, гэр буудлууд бүхий соёлын аялал жуулчлалын төв болгож хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын орчны бүс нийслэлийн Налайх дүүргийн 6 дугаар хороог нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын жишиг суурин болгон хөгжүүлэх төсөл хэрэгжүүлнэ.
- Тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж, хот орчимд иргэд, жуулчид аялах, зугаалах боломжтой амралтын цэгүүдийг тохижуулна.
- Нийтийн эзэмшлийн гудамж талбайд жуулчдад зориулсан мэдээллийн байгууламжууд байрлуулна. Улаанбаатар хотын Жуулчны гудамжны тохижилтын ажлыг эхлүүлнэ.
- Гадаадын иргэд, жуулчдыг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хэрэг зөрчлийг шуурхай шийдвэрлэх зорилгоор нийслэлийн Цагдаагийн газрын бүтцэд олон нийтийн цагдаад түшиглэсэн жуулчны цагдаагийн бүтцийг бий болгож ажиллуулна.
- Улаанбаатар хотын аялал жуулчлалын зорилтот зах зээл Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудад чиглэсэн “Asia’s next hUB” маркетингийн кампанит ажлыг эхлүүлнэ.
- Зочид буудал, дэн буудал, гэр буудал, аялал жуулчлалын үйлчилгээний таних тэмдгийн стандартыг шинэчлэн боловсруулна. Жуулчны үйлчилгээний байгууллагуудад зориулсан “hUB” урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.




Free iOS and  
Android apps  
for visitors



Available on the  
App Store



GET IT ON  
Google Play



Ulaanbaatar Official Travel Guide

Ulaanbaatar City Tourism Department



## НАЙРСАГ УЛААНБААТАР - ЖУУЛЧДАД ЭЭЛТЭЙ ХОТ

Нийслэлчүүдээ ажлын байртай, ашиг орлоготой болгох гол арга зам нь аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал юм. Иргэддээ эдийн засгийн боломжийг олгохын тулд бид найрсаг Улаанбаатарыг цогцлоох болно.

### Э.БАТ-ҮҮЛ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын Захирагч



## УЛААНБААТАР ХОТОД ЖИЛ БҮР ЗОХИОГДОХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, СОЁЛ УРЛАГ, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ



## ЭВЕНТ КАЛЕНДАРЬ

- “UB Winter festival-Улаанбаатарын өвлийн наадам-2014” аялал жуулчлалын арга хэмжээ /2-р сард/
- “Монгол их цам-108” шашин, соёлын арга хэмжээ /2-р сард/
- “Harmonic UB-Сэтгэл татам Улаанбаатар” жуулчдын гэрэл зургийн уралдаан /6-9-р сард/
- “Улаанбаатар марафон” олон улсын марафон гүйлтийн тэмцээн /6-р сард/
- “UB souvenir and gift expo” гар урлал, бэлэг дурсгалын үзэсгэлэн худалдаа /6-р сард/
- “Authentic nomads” нүүдлийн соёлын ил музей /7-р сард/
- “Үндэсний их баяр наадам” /7-р сард/
- “Дээлтэй Монгол наадам” үндэсний соёлын арга хэмжээ /7-р сард/
- “Тал нутгийн марафон” олон улсын марафон гүйлтийн тэмцээн /7-р сард/
- “Taste of UB” олон үндэстний хоолны өдөрлөг /8-р сард/
- “Айрагны баяр-Airag festival” үндэсний ундааны өдөрлөг /9-р сард/
- “UB Art fair” дүрслэх урлагийн үзэсгэлэн яармаг /11-р сард/
- “UB Golden Week - Зул сарын зад хямдрал” /12-р сард/
- Эдгээр арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын жуулчны лавлах 7010-8687 /7010-TOUR/ утсаар авна уу.

### БУСАД АРГА ХЭМЖЭЭ

- “HoReCa” зочид буудал, зоогийн газар, зочлох үйлчилгээний байгууллагуудын үзэсгэлэн /4-р сард/
- “Hospitable UB-Найрсаг Улаанбаатар” аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах олон улсын тэмцээн /4-р сард/
- “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн яармаг /4-р сард/
- “Хог хаягдлын эко шийдэл” уралдаан /6-11-р сард/





## 2014 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Солонгос хэлтэй хөтөч-тайлбарлагчдын мэргэшүүлэх сургалт /2-р сард/
- Япон хэлтэй хөтөч-тайлбарлагчдын мэргэшүүлэх сургалт /3-р сард/
- “Музейд тайлбар хийх нь” хөтөч-тайлбарлагчдын мэргэшүүлэх сургалт /4-р сард/
- Үйлчилгээний ажилтнуудад зориулсан ярианы англи хэлний сургалт /4, 5-р сард/
- Налайх дүүргийн 6-р хороо буюу Горхи-Тэрэлжийн бүсийн иргэдэд зориулсан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх сургалт /5-р сард/
- “Аялал жуулчлал ба эрсдлийн менежмент” зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан үзүүлэх сургалт /5-р сард/
- Хот орчмын жуулчны бааз, гэр буудлын үйл ажиллагаа



- эрхлэгчдэд зориулсан үйлчилгээний сургалт /5, 6-р сард/
- Зочид буудал, зоогийн газар, дэн буудлын ажилтнуудад зориулсан мэргэжил сурталчлах өдөрлөг, сургалт – дүүрэг бүрт /5, 6-р сард/
- Жуулчидтай шууд харилцдаг төрийн албан хаагчдад зориулсан ярианы англи хэлний сургалт
- Жуулчидтай шууд харилцдаг төрийн албан хаагчдад зориулсан харилцаа, хандлагын сургалт
- Таксины жолооч нарт зориулсан радио сургалт

## 2014 ОНООС УЛААНБААТАР ХОТ, ХОТ ОРЧИМД ХЭРЭГЖИХ ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨСЛҮҮД




**Гандантэгчэнлин хийдийн цогцолбор төсөл**



**Монгол наадам цогцолбор төсөл**



**Түмэн хишигтэн**




**Их майдар төсөл**



**Зайсан соёл амралтын цогцолбор төсөл**

**Бусад ...**

## ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВ



Аялал жуулчлалтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө

Жуулчны мэдээллийн лавлах утас: 7010-8687 (7010-TOUR)

Хаяг: Бага тойруу-15, ЧД, 4-р хороо, Нийслэлийн засаг зхиргааны 4-р байр

Салбар: Төмөр замын төв буудал